



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/61

Даланзадгад

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 112, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 52 дугаар тогтоол, Эрүүл Мэндийн Сайдын 2018 оны А/295 дугаар тушаалыг тус тус үндэслэн эмч, эмнэлгийн ажилчдын эрүүл мэндийг дэмжих зорилгоор ТУШААХ нь:

1. Өмнөговь аймгийн хэмжээнд эмч эмнэлгийн ажилчдын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих зорилгоор “Хавдрын эсрэг хамтдаа 2018” аяны үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажиллах чиглэлийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Эрүүл мэндийн байгууллагууд өөрийн байгууллага дээрээ одоо ажиллаж байгаа, тэтгэвэрт гарсан эмч, ажилтнуудын архаг хууч өвчин, хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгээс илрүүлсэн шаардлагатай ажилтнуудыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвд нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээнд хамруулан хариуцлагатай ажиллахыг төр, хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгууллагын дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Хоёрдугаар шатлалын үзлэгээр төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулах эмч, ажилтнуудын нэрсийг гарган, үзлэгт хамруулахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв /Я.Болдбаатар/, Эрүүл мэндийн байгууллагын дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Эрүүл Мэндийн Байгууллагуудаас урьдчилан ирүүлсэн нэрсийн жагсаалтын дагуу гурав дугаар шатлалын үзлэгийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, тайлагнаж ажиллахыг Ажлын хэсэг /М.Цэндсүрэн/-т үүрэг болгосугай.


5. Эрүүл мэндийн үзлэг арга хэмжээний үр дүнд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтэс /Б.Мидэрсүрэн/-т даалгасугай.

ДАРГА



Ц.ӨНӨРЖАРГАЛ

Эрүүл мэндийн газрын даргын
2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн
А/61 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт



**“ХАВДРЫН ЭСРЭГ ХАМТДАА 2018” АЯНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАН
АЖИЛЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн дарга:

М.Цэндсүрэн /Эрүүл мэндийн газрын удирдлага төлөвлөлтийн
хэлтсийн дарга/

Гишүүд:

Ж.Отгонбайгаль /Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга/

Б.Мидэрсүрэн /Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга/

М.Булганчимэг /Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга/

Д.Түвшинзул /Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмчилгээ эрхэлсэн
орлогч дарга/

Ц.Мандах /Эрүүл мэндийн газрын хүний нөөцийн мэргэжилтэн/

Т.Сайнжаргал /Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хавдрын их эмч/

Д.Дэлгэрсайхан /Эрүүл мэндийн салбарын ахмадын зөвлөлийн дарга/

Нарийн бичгийн дарга:

М.Цэцэгсүрэн /Нийгмийн эрүүл мэндийн төвийн халдварын бус
өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн/